



НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ ХК

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 1-р хороо
Утас: +976-11-344932, 34-22-32, 34-17-18 Факс: 976-11-341697 И-мэйл: nekheesgui@beren.mn

2023 он 3 сарын 19 өдөр

№ 1/23

Улаанбаатар хот

“НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит Хурал хуралдуулах тухай

“Нэхээсгүй Эдлэл” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн хурлын тов, газрыг тогтоох, хурлаар хэлэлцэх асуудлууд, зар хүргэх, бүртгэх өдөр, саналын хуудас, хурлын бэлтгэл ажиллагааг хангах зэрэг асуудлуудлыг хэлэлцээд Компаний тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.2.1, 60.2.2, 60.2.3, 60.2.4, 60.2.5, 60.2.6 60.2.7, 60.2.8, 60.29, 62.1.7, 67 дугаар зүйлийн 67.1 дугаар зүйлийг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар Тогтоолыг тус тус удирдлага болгон ТУЗ-ийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Нэхээсгүй Эдлэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр 09:00 цагт Улаанбаатар хотод “Нэхээсгүй Эдлэл” ХК-ийн байр, хурлын их танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - a) Компанийн 2022 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарах дүгнэлтийг хэлэлцэж батлах.
 - b) Тус компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх.
 - c) Компанийн 2023 оны бизнесийн төлөвлөгөөг хэлэлцэж батлах.
 - d) ТУЗ-ийн гишүүдийг сонгох.
 - e) Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын нэг сонинд, радио болон телевизийн аль нэгээр мэдээлсүгэй. Хурлын зар мэдээг анхны мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа өдөр тутмын нэг сонинд, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгнээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигч нь энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд ХУД, 15-р хороо "Нэхээсгүй Эдлэл" ХК дээр ирж танилцаж болохыг дурьдсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 1 дүгээр хавсралтанд заасан баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ны агуулгыг 2 дугаар хавсралтаар баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудсыг, хүлээн авах сүүлчийн өдрийг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 8 цаг 40 минут байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Б.Ганбат-ыг, хурал зохион байгуулах комиссын даргаар Н.Мөнхбат-ыг, хурал зохион байгуулах комиссын гишүүнээр Х.Энхсайхан нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Ц.Намхайг, гишүүнээр Х.Энхсайхан нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА /Б. ГАНБАТ/

